



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 4/478

Арвайхээр

**Малд зохиомол хээлтүүлэг хийх тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн, 29.1.3."а", Малын генетик нөөцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн "Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай" 03/04 дүгээр тогтоолын 2.6.115, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 03/03 дугаар тогтоолын 2.4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нарийнтээл сумын "Тээлийн улаан" нутгийн хэвшлийн 300 хүртэлх ямаа, Арвайхээр сумын үржлийн цөм сүргийн 120 хүртэлх хонинд шилэн сонголт явуулж, зохиомол хээлтүүлэг хийх ажлын хэсгийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Зохиомол хээлтүүлэг хийхэд шаардагдах нийт 5887000 (таван сая найман зуун наян долоон мянга) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Малд зохиомол хээлтүүлэг хийх ажлыг бүртгэл, тооцоотой, холбогдох дүрэм, журам, зааврын дагуу технологийн хугацаанд чанартай зохион байгуулж үр дүнг нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын болон аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга (Б.Цэнгэл)-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101017

Аймгийн Засаг даргын 2021 оны 10.  
дугаар сарын 05-ны өдрийн 4/4 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



## БОГ МАЛД ЗОХИОМОЛ ХЭЭЛТҮҮЛЭГ ХИЙХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Б.Цэнгэл (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга)

Нарийн бичгийн дарга: Ж.Энхтуяа (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн)


Гишүүд: С.Бат-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн)

Т.Эрдэнэбаяр (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн)

Б.Шинэбаатар (Нарийнтээл сумын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

-оОо-

Аймгийн Засаг даргын 2021 оны 10..  
дугаар сарын 05..-ны өдрийн Д/9/28 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт



**БОГ МАЛД ЗОХИОМОЛ ХЭЭЛТҮҮЛЭГ ХИЙХЭД ШААРДАГДАХ  
БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАРДАЛ**

Д/д	Төрөл	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ /төг/	Тоо, хэмжээ	Нийт зардал
1	1 удаагын бээлий	хайрцаг	32500	4	130000
2	метилын спирт 70	л	12900	10	129000
3	Вазелин	сав	10000	4	40000
4	Ороо идэвхжүүлэгч	тун	3000	300	900000
5	Гүн хөлдөөсөн үр	тун	4000	100	400000
6	Марль	м	1000	8	8000
7	Хуурай салфетка	ш	3000	6	18000
8	Нойтон салфетка	ш	5000	10	50000
9	Духны гэрэл	Ш	15000	3	45000
10	Түлээ нүүрс	шуудай	4500	10	45000
12	Өндөг	ш	420	100	42000
13	Лууван	Кг	1500	10	15000
14	Хивэг	шуудай	19000	2	38000
15	Үр шингэлэгч /0.9% NaCl/	ш	2500	4	10000
19	Шатахууны зардал	л	2100	200	420000
Дүн					2.290.000

**ЗОХИОМОЛ ХЭЭЛТҮҮЛЭГ ХИЙХ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН  
ТОМИЛОЛТЫН ЗАРДАЛ**



Д/д	Төрөл	Мэргэжилтний тоо	1 өдрийн томилолт /төг/	Хоног	Томилолт /төг/
2	Айгийн ХХААГазрын мэргэжилтэн	3	26500	14	1113000
3	Жолооч	1	26500	14	371000
4	Сумдын МЭҮТасгийн мэргэжилтэн	3	26500	14	1113000
5	Малчны хөлс	2	500000		1000000
<b>Дүн</b>					<b>3.597.000</b>

**НИЙТ ЗАРДАЛ**

д/д	Зардлын нэр	Нийт зардал
1	Багаж, тоног төхөөрөмжийн зардал	2.290.000
2	Томилолт	3.597.000
<b>Нийт</b>		<b>5.887.000</b>

-оОо-